




2024 9-сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q2	2024Q1	2023Q2	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	14,407	6,065	13,631	5.7%
Ажилгүйдлийн түвшин	%	5.76%	5.11%	5.76%	0.0%
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,465	2,284	1,890	30.4%
Гадаад өр	сая ам доллар	34,867	35,003	33,790	3.2%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M08	2024M07	2023M08	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	10,686	9,327	10,004	6.8%
Зэс	сая ам доллар	1,971	1,747	1,775	11.0%
Нүүрс	сая ам доллар	6,126	5,361	5,735	6.8%
Нийт импорт	сая ам доллар	-7,502	-6,411	-5,947	26.1%
Хэрэглээ	сая ам доллар	-2,199	-1,852	-1,701	29.2%
Түүхий эд	сая ам доллар	-635	-549	-554	14.6%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-3,213	-2,747	-2,429	32.3%
Шатахуун	сая ам доллар	-1,444	-1,253	-1,254	15.1%
Тэнцэл	сая ам доллар	3,185	2,916	4,057	-21.5%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	8,981	9,385	8,348	7.6%
Нүүрс	\$/тонн	154	142	153	0.9%
Газрын тос	\$/баррель	79	84	85	-7.2%
Алт	\$/трой унц	2,468	2,394	1,919	28.6%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	1,371	1,373	1,818	-24.6%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	18,689	16,634	14,609	27.9%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-17,318	-15,262	-12,791	35.4%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M08	2024M07	2023M08	
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	41,565	41,754	32,642	27.3%
ХҮИ (C2015)	индекс	146.7	145.5	137.8	6.5%
Бодлогын хүү	%	11.0%	11.0%	13.0%	-15.4%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,381	3,381	3,473	-2.6%
Төгрөгийн хадгаламж	%	11.5%	11.3%	11.1%	3.9%
Валютын хадгаламж	%	3.5%	3.9%	3.4%	2.9%
Төгрөгийн зээл	%	17.0%	16.8%	16.4%	3.2%
Валютын зээл	%	9.5%	10.7%	10.2%	-7.6%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	4,704	4,737	3,933	19.6%
Үнэт цаас	сая ам доллар	1,207	2,455	1,755	-31.2%
Харилцах, хадгаламж	сая ам доллар	2,841	1,617	1,638	73.5%
ОУВС-д байршуулсан хөрөнгө	сая ам доллар	7	7	7	1.6%
Зээлжих тусгай эрх	сая ам доллар	96	97	109	-11.9%
Мөнгөжсөн алт	сая ам доллар	553	560	424	30.3%

ФИТЧ АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ АХИУЛЖ “В+” ҮНЭЛГЭЭТЭЙ БОЛГОЛОО.

- Фитч агентлаг Монгол улсын зээлжих зэрэглэлийг “В+” Тогтвортой төлөвт болгон ахиуллаа. Зэрэглэл нэмэгдэхэд хэрэгжүүлж буй өрийн удирдлагын бодлого, уул уурхайн салбар дагасан өсөлт, улс төрийн тогтвортой байдал зэргээс шалтгаалсан байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ 8 ДУГААР САРД УЛСЫН ХЭМЖЭЭНД 6.5 ХУВЬТАЙ ГАРЧ ЭРГЭН ЭРЧИМЖЛЭЭ.

- 2022 оны эцсээс энэ оны 6 дугаар сар хүртэл тогтвортой буурч байсан инфляцын түвшин энэ оны 8 дугаар сард өмнөх сараас 1 нэгж хувиар өсөж мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 3.4 нэгж хувиар, бензин түлшнээс бусад импортын барааны үнэ 2.1 нэгж хувиар тус тус нөлөө үзүүлсэн байна. Цалин, тэтгэврийн нэмэгдлээс шалтгаалж дотоодын эрэлт идэвхжиж нийт импорт өмнөх оны мөн үеэс 26 хувиар өсжээ.
- Нийт импортын 43 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн буюу машин механизм, тээврийн хэрэгсэл, барилгын материал бүрдүүлсэн бол 29 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, харин 19 хувийг нефтийн бүтээгдэхүүнүүд бүрдүүлсэн байна.

МОНГОЛБАНК БОДЛОГЫН ХҮҮГ ЭНЭ ОНД 3 УДАА ТУС БҮР 1 НЭГЖ ХУВИАР БУУРУУЛЖ 10 ХУВЬД ХҮРГЭЛЭЭ.

- Инфляцын түвшин дунд хугацаандаа зорилтот интервалд тогтворжих хүлээлттэй байгаа тул Монголбанкнаас бодлогын хүүг ахин 1 нэгж хувиар бууруулж 10 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Гэсэн хэдий ч зээлийн өсөлт эрчимжиж, санхүүгийн салбарт эрсдэл учрахаас давхар сэргийлж төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлэн 10 хувьд хүргэхээр шийдвэрлэлээ.
- Худалдааны түнш орнуудын инфляц бага, валютын ханш тогтвортой хадгалагдах хүлээлттэй байгаа нь бодлогын хүү буурахад голлон нөлөөлжээ.
- Нөгөө талдаа мөнгөний нийлүүлэлт 8 сарын байдлаар 41 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 8.9 их наяд төгрөгөөр буюу 27.7 хувиар өслөө. Онолын хувьд мөнгөний нийлүүлэлт өсөхөд нь инфляцыг нэмэгдүүлдэг тул оны эцэст болон ирэх жилд инфляц одоогийн түвшнээс өсөх хүлээлттэй байна.

2024 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛ ХИЙГДЭЖ, 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ ТАНИЛЦУУЛАГДЛАА.

- Төсвийн тодотголын үр дүнд энэ оны төсвийн зардлыг 30.5 их наяд төгрөг болгон өмнөх оноос 8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба 8 сарын байдлаар төсвийн зардал 17.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 35 хувиар нэмэгдсэн байна. Төсвийн зардлын гүйцэтгэлийг ангилан задалбал нийт 17.3 их наяд төгрөгийн 79 хувийг урсгал зардал эзэлж байгаа бол 19.3 хувийг хөрөнгийн зардал, 1.6 хувийг цэвэр зээл эзэлж байна. Цалин хөлс, нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмж, халамжийн сангийн зардал нь урсгал зардлын 75 хувийг цэврээр бүрдүүллээ.
- Харин 2025 оны төсвийн төслийг УИХ-д өргөн барьсан ба үүнд нийт зардлыг 35.6 их наяд төгрөг болгож 5 их наядаар нэмэгдүүллээ. Мөн ирэх онд төрийн албан хаагчдын цалин болон өндөр настны тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан 6%-р нэмэгдүүлэх тухай дурдагдсан байна.

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 22 ХУВИАР БУУРЧ, 3.1 ТЭРБУМЫН АШИГТАЙ ГАРЛАА.


- Нийт экспортын 58 хувийг чулуун нүүрс эзэлж байгаа бол 19 хувийг зэсийн хүдэр, баяжмал эзэлсэн байна. Ийнхүү нийт экспорт 10.6 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өссөн бол нийт импорт 7.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 26.1 хувиар нэмэгджээ. Эхний 8 сарын байдлаар нүүрсний экспорт биет хэмжээгээрээ өмнөх оны мөн үеэс 32 хувиар өсөж 54 сая тоннд хүрчээ. Засгийн газраас нүүрсний биет хэмжээг оны эцэст 78 сая тоннд хүргэх зорилттой байна.
- Нүүрсний биет хэмжээ өмнө жилтэй харьцуулахад өндөр үзүүлэлттэй байгаа ч нүүрсний хилийн үнэ буурсан байна. Өмнө жилийн 8 сард хилийн дундаж нүүрсний үнэ 113 ам.доллар байсан бол энэ оны 8 сард 103.6 ам.долларт хүрч 9 хувиар буурлаа.

ОЛОН УЛСЫН ТӨВ БАНКУУД БОДЛОГЫН ХҮҮГЭЭ БУУРУУЛЖ ЭХЭЛЛЭЭ.

- ХНС 9 сарын мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүгээ 50 нэгжээр бууруулж 4.875%-д хүргэсэн бол Европын холбоо 0.25 нэгжээр бууруулж 3.5%-д хүргэлээ. Ийнхүү бодлогын хүү буурч байгаа нь бүс нутгуудад инфляц зорилтот түвшинд ойртож тогтворжсонтой холбоотой байна.


БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ны өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ



Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ




Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.

ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Дархлан

Цахим хаяг: darkhlan@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

С. Цацрал

Цахим хаяг: tsatsral.sa@golomtbank.com